



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/578

Мөрөн сум

Нэрлэсэн жилийн ажил дүгнэж,
урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", 29.1.6 "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус X хуралдааны 01 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэрлэсэн жилийн ажлын үр дүн, хэрэгжилтийг сум, агентлаг, байгууллагын түвшинд үнэлэх ажлын хэсгийг нэгдүгээр, шалгарсан шилдэг сум, байгууллагын шагналд зарцуулагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийг дэмжих" жилийн ажлын үр дүнг дүгнэж, нэрлэсэн жилийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан шилдэг сум, шилдэг агентлаг, байгууллагуудыг шалгаруулж урамшуулсугай.

3. Дээрх 7,558,000 (Долоон сая таван зуун тавин найман мянга) төгрөгийг "Хамгаалагдсан хүүхэд-Аз жаргалтай гэр бүл" дэд хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Базар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа) нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД